

МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

Ангилалтын код 13.340.20. 13.100

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэнд. Хувийн хамгаалах хувцас хэрэгсэл. Толгой хамгаалах хэрэгсэл - Нүд хамгаалах хэрэгсэл. Техникийн ерөнхий шаардлага	MNS 5389:20XX
Occupational safety and health. Personal protective equipment. Head protection device - Eye protection equipment. General technical requirements	MNS 5389:2004-ийн оронд

Стандарт, хэмжил зүйн газрын даргын ... оны ... дүгээр сарын ...-ны өдрийн ... дугаар тушаалаар батлав.

Энэ стандарт нь ... оны ... дүгээр сарын ... -ны өдрөөс эхлэн хүчинтэй.

1 Хамрах хүрээ

Энэ стандарт нь үйлдвэрлэл, үйлчилгээ, боловсролын байгууллага, ахуйн хэрэглээ зэрэгт тохиолдож болзошгүй төрөл бүрийн аюулаас хүний харааны эрхтэнд гэмтэл учруулах эсвэл харааны чадварыг муутгах эрсдэлийг багасгах зорилготой нүд хамгаалах бүх төрлийн хувийн хамгаалах хэрэгслийн ерөнхий шаардлагыг тогтооход оршино.

Энэхүү стандартад дараах төрлийн цацрагийн нөлөөг бууруулахад нүд хамгаалах хэрэгсэл хамаарахгүй. Үүнд:

1. Цөмийн цацраг
2. Рентген туяа
3. Радио долгион
4. Лазер туяа
5. Бага температуртай инфра улаан эх үүсвэрийн цацраг
6. Олон нийтийн хэрэглээнд зориулагдсан нарны хамгаалалтын шил

2 Норматив эшлэл

Энэ стандартад дараах эш татсан стандарт, баримт бичгийг хэрэглэнэ. Он заасан эшлэлийн хувьд зөвхөн эш татсан хэвлэлийг хэрэглэнэ. Он заагаагүй эшлэлийн хувьд хамгийн сүүлийн хэвлэл (нэмэлтийн хамт)-ийг хэрэглэнэ.

EN 166, Хамгаалалтын нүдний шил стандарт

ISO 16321-1, Нүд болон нүүр хамгаалах хэрэгсэл, Ерөнхий шаардлага

MNS 4931, Хамгаалах хэрэгсэл, Ерөнхий шаардлага, ангилал

3 Нэр, томъёо тодорхойлолт

3.1

хувийн хамгаалах хэрэгсэл

Хөдөлмөрлөх явцад ажлын байрны аюултай хүчин зүйлийн нөлөөллөөс хүнийг

хамгаалах зориулалт бүхий хэрэгсэл.

3.2

нүд хамгаалах хэрэгсэл

Гадны биет, хурц гэрэл, хортой туяа, химийн бодис, температурын нөлөөллөөс нүдийг хамгаалах зориулалтын хэрэгсэл.

4 Ангилал

Нүд хамгаалах хэрэгслийг зориулалтаар нь дараах байдлаар ангилна.

4.1 Энгийн нүд хамгаалах хэрэгсэл

4.2 Дуулганд бэхлэгдсэн нүд хамгаалах хэрэгсэл

4.3 Хурц гэрэл, туяанаас нүд хамгаалах хэрэгсэл

5 Ерөнхий зүйл

5.1 Зорилго

Энэ стандартын зорилго нь ажлын байран дахь хими, физик, биологийн аюултай хүчин зүйлийн нөлөөллөөс ажилтны нүдийг хамгаалах хэрэгсэлд тавих шаардлагыг тогтооход оршино. Үүнд:

- 1) Механик үйлчлэлээс
- 2) Идэмхий химийн бодисын нөлөөллөөс
- 3) Оптик (гэрлийн) цацрагаас
- 4) Хайлсан металл болон халуун хатуу биетүүдийн хэсгээс
- 5) Шингэний дусал болон үсэрсэн цацлагуудаас
- 6) Том ширхэгт аэрозоль (тоос)-оос
- 7) Хий болон нарийн ширхэгт аэрозоль-с
- 8) Дулааны цацрагаас
- 9) Эдгээр хүчин зүйлсийн аливаа хослолоос

5.2 Ерөнхий шаардлага

5.2.1 Нүд хамгаалах хэрэгсэл нь MNS 4931, Хамгаалах хэрэгсэл, Ерөнхий шаардлага, ангилал стандартын шаардлагыг хангасан байна.

5.2.2 Нүд хамгаалах хэрэгсэл нь зориулалтын дагуу ашиглахад тохирсон байна.

5.2.3 Нүд хамгаалах хэрэгсэл нь эрх бүхий байгууллагаар шалгагдаж баталгаажуулсан гэрчилгээтэй байна.

5.2.4 Нүд хамгаалах хэрэгсэл нь хэрэглээний явцад зовуурь үүсгэх, эсвэл гэмтэл учруулах төвийж гарсан хэсэг, хурц ирмэг болон бусад доголдол агуулж болохгүй.

5.2.5 Хүний арьстай харьцах хэсэгт хэрэглэгдэх материал нь арьс цочроохгүй, эрүүл ахуйн шаардлага хангасан байна.

5.2.6 Толгойд бэхлэх зориулалттай бүслүүр /тууз/ нь хүний толгойд хүрэлцэх бүх уртаараа 10 мм-ээс багагүй өргөнтэй, уртыг нь тохируулах боломжтой, эсвэл өөрөө тохируулагддаг бүтэцтэй байна.

5.3 Тусгай шаардлага

- 5.3.1 Нүд хамгаалах хэрэгсэл нь хөдөлмөрийн нөхцөл, ажлын орчноос шалтгаалан тунгалаг (салхины хүч нь 12-190м/с), гэрлийн бууралттай (0-11DIN бууруулах) байна.
- 5.3.2 Өнгө үзэмжтэй, хөнгөн, арьсанд харшил өгөхгүй PVC- полиамид, полиэтилен материалаар хийсэн байна.
- 5.3.3 Нүд хамгаалах хэрэгсэл нь хэрэглэхэд хялбар, эвдэрсэн эд ангийг сольж засварлах бүрэн боломжтой байна.
- 5.3.4 Нүдэнд орж болзошгүй механик биет болон хурц гэрлээс хамгаалах онцлогоос хамааруулан шилний зузаан нь 1мм-ээс 4мм хүртэл байна.
- 5.3.5 Ажлын орчноос шалтгаалан нүдний шилийг дуулганд угсарч, хэрэглэнэ.

6 Техникийн үзүүлэлт, бүтэц

6.1 Нүд хамгаалах хэрэгслийн техникийн үзүүлэлт:

Хүснэгт 1

Нүд хамгаалах хэрэгслийн техникийн үзүүлэлт

Салхины хүчийг тэсвэрлэх чадвараар нь:	
Сайжруулсан	S (12 m/c)
Богино зайнаас	F (45 m/c)
Дунд зайнаас	B (120 m/c)
Холын зайнаас	A (190 m/c)
Зориулалтаар нь:	
Химийн бодис	3
Гадны биет	4
Хий болон тоос шороо	5
Цахилгаан нум	8
Халуун хайлмал металл	9
Мананцар	И

6.2 Хамгаалалтын нүдний шилний бүтэц:

6.2.1 Энгийн нүдний шилний бүтэц

- Дан шил
- Нүдний шилний хүрээ
- Бэхлэгч оосор
- Агааржуулагч хавхалга (4-6ш)

6.2.2 Дуулганд бэхлэгдсэн нүдний шилний бүтэц:

Энэхүү иж бүрдлийн дуулга нь:

- a. Дуулганы их бие
- b. Толгойд углах бүслэвч ба тохируулагч цагариг
- c. Толгойн оройн хөндийрүүлэгч татуурга
- d. Хөлсийг шингээх жийргэвчээс тус тус бүрдэх ба нүдний шил нь энэхүү стандартын 6.2.1-д заасан шаардлагыг хангасан байна.

6.2.3 Хурц гэрэл, туяанаас нүд хамгаалах нүдний шилний бүтэц

- a. Нүдний шил нь энэхүү стандартын 6.1-д заасан шаардлагыг хангасан байна.
- b. Хурц гэрэл, туяаны нөлөө бууруулах шил.
- c. Тогтоогч хавчаар

7 Хэрэглэх ба шалгах арга

7.1 Нүдний шилийг хэрэглэх арга

- 7.1.1 Нүдний шилээ зүүж, бэхлэгч оосроор хэмжээг тохируулна.
- 7.1.2 Бууруулагч шилийг ашиглалтын зааврын дагуу сонгож хэрэглэнэ.

7.2 Дуулганд бэхлэгдсэн нүдний шилийг хэрэглэх, шалгах арга

- 7.2.1 Дуулганд нүдний шилийг зөв угсарсан эсэх
- 7.2.2 Дуулганы углагч бүслэвчийг толгойны хэмжээнд тохируулж, тохируулагч цагаригаар бэхлээд, хөдөлгөөнгүй суулгаж өмсөнө.

7.3 Хадгалах нөхцөл, хугацаа

- 7.3.1 Нүд хамгаалах хэрэгслийг битүү саванд (хагарахаас болгоомжил гэсэн тэмдэгтэй) хийж хадгална. Хадгалалтын хугацааг үйлдвэрлэгчийн техникийн бичиг, баримтад дурдсан хугацаагаар тогтооно.
- 7.3.2 Металлын зэврэлт, резин болон хуванцар эд ангиудын гэмтэл үүсгэх бодистой нэг өрөөнд хадгалахыг хатуу хориглоно.

8 Анхаарах зүйл

- 8.1 Нүдний шилний техникийн үзүүлэлт, тухайн ажилчны хөдөлмөрийн нөхцөл хоёр бүрэн тохирч байна.
- 8.2 Нүдний шилний техникийн бичиг баримт, эрх бүхий байгууллагаар баталгаажсан зөвшөөрөл, нэг бүрийн хамгаалах хэрэгсэл гурав хоорондоо тохирч байна.

ТӨГСӨВ.

А хавсралт
(мэдээллийн)

Хүснэгт А.1

Нүд хамгаалах хэрэгслийн ангилал, техникийн үзүүлэлт

№	Нүд хамгаалах хэрэгслийн ангилал	Техникийн үзүүлэлт
1	Энгийн шил	12-45 м/с
2	Давхар шил	12-45 м/с
3	Хурц гэрэл туяанаас хамгаалах шил	45-195 м/с